



**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРААС
 "ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛ"-ЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ
 АЖЛЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2022.01.10

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Зорилго	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Газрын харилцааны салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.			
Үр дүн	<p>1.1. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, Газрын харилцааны салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэн холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангасан байна.</p> <p>1.2. Салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогын хэрэгжилтийн талаарх мэдлэг, арга замын талаарх ойлгоцыг бүх түвшинд түгээсэн байна.</p> <p>1.3. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд болон иргэнийг ажилд авахад нас, хүйс, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, газрын байршил болон бусад зүйлээр үл ялгаварлах, ажлын байранд бэлгийн дарамт шахалт үүсэхгүй байх зохицуулалт, нөхцөл бүрдэнэ.</p>			
Зорилт	<p>1. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, Газрын харилцааны салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах;</p> <p>2. Салбарын ажилтнуудын зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендэрийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаагаар мэдлэг, судалгаа, мэдээлэлд суурилан хэрэгжүүлэх.</p>			

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх Байгууллага
Зорилт 1: Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, Жендэрийн үндэсний хорооноос гарсан шийдвэр, Газрын харилцааны салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах.				
<p>1.1. Жендэрийн тэгш байдлыг хангах, Газрын харилцааны салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, энэ чиглэлд төр, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.</p>	<p>1. Газрын харилцааны салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх арга замын талаар хэлэлцүүлэг зөвлөгөөнд хамрагдсан байна.</p>	<p>ШҮ1: Хэлэлцүүлэг-1; ШҮ2: Хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн; ШҮ3: Сургалт, сурталчилгааны ажлын тоо.</p>	<p>II, IV улиралд</p>	<p>Жендэрийн үндэсний хороо, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /ГЗБГЗЗГ/, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/, Мэргэжлийн байгууллага</p>
<p>1.2. Газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн тайланд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын талаарх мэдээллийг нас, хүйсээр ангилан гаргаж, мэдээллийг бүрдүүлэх.</p>	<p>1. Газрын нэгдмэл сан болон салбарын хүний нөөцийн мэдээллийг нас, хүйсээр ангилан гаргадаг болсон байна. 2. Салбарын үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөхөд суурь судалгаатай болсон байна.</p>	<p>ШҮ1: Мэдээлэлд хамрагдалтын тоо; ШҮ2: Хэрэгжилтийн хувь</p>	<p>Жилдээ</p>	<p>ГЗБГЗЗГ</p>
<p>1.3. Салбарын чиглэлээр төсөл, хөтөлбөр, бодлого боловсруулалт, хэрэгжилтэд болон байгууллага, хамт олны тулгамдсан асуудлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн бүлгийн оролцоотой хэлэлцэн, шийдвэрлэж байх.</p>	<p>1. Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог хангах, тэдний хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. 2. Байгууллага, хамт олны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тэдний санал, бодлыг сонссон байна.</p>	<p>ШҮ1: Үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийн тоо, тэдний хүйсийн харьцаа; ШҮ2: Ажлын үр дүн</p>	<p>Жилдээ</p>	<p>ГЗБГЗЗГ, НГЗБА, 21 аймгийн ГХБХБГ</p>

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
<p>1.4.Салбарын мэргэжилтнүүд, инженер техникийн болон бусад ажилтнуудад жендэрийн эрх тэгш байдал, мэдлэг олгох ажлыг Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхтэй аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.</p>	<p>1.Жендэрийн эрх тэгш, ил тод байдал хангагдсан байна.</p>	<p>ШҮ1:Сургалтын хөтөлбөрт тусгагдсан заалт хэрэгжсэн байх; ШҮ2: Хэрэгжилтийн хувь</p>	<p>Жилдээ</p>	<p>ГЗБГЗЗГ, НГЗБА, 21 аймгийн ГХБХБГ, Мэргэжлийн байгууллага</p>
<p>1.5.Жендэрийн Үндэсний хороо болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад байгууллага, мэргэжлийн байгууллага, ТББ-ын удирдлагуудыг хамруулах арга хэмжээг авах.</p>	<p>1.Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон сонирхсон албан хаагчдын энэ талын мэдлэг дээшилсэн байна. 2.Сургагч багш нартай болсон байна.</p>	<p>ШҮ1:Сургалтын болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо</p>	<p>Жилдээ</p>	<p>ГЗБГЗЗГ, НГЗБА, 21 аймгийн ГХБХБГ, Мэргэжлийн байгууллага</p>
<p>1.6.Байгууллагын удирдах ажилтнууд болон албан хаагчдыг жендэр, хүний эрхийг хангах чиглэлээр сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>1.Ажилтнууд жендэрийн эрх тэгш байдал, түүнийг хэрэгжүүлэх талаар мэдлэг, аргачлал эзэмшиж, хэрэглэх чадамжтай болсон байна.</p>	<p>ШҮ1:Сургалтын болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо:</p>	<p>Жилдээ</p>	<p>ГЗБГЗЗГ, НГЗБА, 21 аймгийн ГХБХБГ</p>

**Зорилт 2: Салбарын албан хаагчдын зохистой хөдөлмөр эрхлэлт, харилцааг эрх тэгш байдлын үндсэн дээр
жендэрийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх.**

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
<p>2.1.Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах чиглэлээр байгууллагын албан хаагчдын дунд санал асуулга явуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, холбогдох арга хэмжээг авч байх, ажлын ачаалал, хөдөлмөрийн цаг, нормыг баримтлан хэрэгжүүлэх.</p>	<p>1.Санал асуулга-23 2.Ажилтнуудаа шинжилгээ, оношилгоо, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. 3.Байгууллагын албан хаагчдын нас, хүйс, албан тушаал, цалин, чөлөө, нийгмийн баталгааны чиглэлээрх мэдээлэл бүхий судалгааг харьцуулан гаргаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.</p>	<p>ШҮ1:Асуулга явуулсан байгууллагын тоо; ШҮ2:Шинжилгээ, оношилгоонд хамруулсан албан хаагчдын тоо; ШҮ3:Судалгаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн;</p>	<p>Жилдээ</p>	<p>ГЗБГЗЗГ, НГЗБА, 21 аймгийн ГХБХБГ</p>
<p>2.2.Иргэн ба албан хаагчийг ажилд авах болон хүний нөөцийн асуудлаар ялгаваралгүйгээр шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, шударга, хувь хүнтэй зөвшилцлийн замаар шийдвэрлэх нөлөөллийг бий болгох арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх.</p>	<p>1.Хүний нөөцийн талаар гарсан шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна. 2.Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албанд жендэрийн тэгш байдлын баталгааг хангасан байна.</p>	<p>ШҮ1:Шийдвэр хууль тогтоомжийн дагуу гарсан байх; ШҮ2:Хүний нөөцийн талаарх шийдвэртэй холбогдон гарсан гомдол, саналын тоо;</p>	<p>Жилдээ</p>	<p>ГЗБГЗЗГ, НГЗБА, 21 аймгийн ГХБХБГ</p>
<p>2.3.Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдөх, урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулан бэлгийн дарамт</p>	<p>1.Хөдөлмөрийн харилцаа тэгш зарчмаар явагдсан байна. 2.Ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн болон бусад дарамт шахалт гарахгүй байна. 3.Гарсан зөрчлийг үл тэвчих орчин бүрдсэн байна.</p>	<p>ШҮ1:Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх; ШҮ2.Зохион байгуулсан ажлын тоо.</p>	<p>Жилдээ</p>	<p>ГЗБГЗЗГ, НГЗБА, 21 аймгийн ГХБХБГ</p>

болон бусад шахалт дарамтыг үл
тэвчих орчныг бүрдүүлэх.

Төлөвлөгөөг хянасан: ЗУХАГ-ын дарга



— Р.Ганхуяг

Төлөвлөгөө боловсруулсан:

ЗУХАГ-ын Хүний нөөцийн асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн



С.Ганцэцэг